

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

ТУЗ-ийн хараат бус гишүүний баталгаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч овогтой..... би дор дурдсан баталгаа гаргаж байна.

1. Би өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй болно.
2. Би өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон тус компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч хуулийн этгээдэд сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй, одоо ч ажил, албан тушаал эрхэлдэггүй болно.
3. Би төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй болно.
4. Би сүүлийн 5 жилд улс төрийн албан тушаал хашиж байгаагүй болно.
5. Ял шийтгэл эдлээгүй болно.
6. Би “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай бизнесийн аливаа холбоогүй бөгөөд тус компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэгэн хамааралгүй болно.
7. Би зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болно.
8. Уул уурхай, хууль, худалдаа, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, уг салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай болохоо нотолж байна.
9. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;
10. Би санхүүгийн зах зээлийн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагад эрх бүхий албан тушаалт хашдаггүй болно.
11. Зөрчлийн улмаас ажиллаж байсан байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 3 жил өнгөрсөн байх;
12. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үед захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш 3 жил өнгөрсөн байх.
13. Би санхүүгийн зах зээлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьцаа эзэмшигч, эсхүл хувьцааны хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй болно.
14. Би “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ажил, үйлчилгээг хүлээн авах, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, эсхүл тус компанид ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах зэрэг байдлаар компанитай харилцах замаар их хэмжээний хэлцэл байгуулсан аливаа этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн биш.
15. Би Сангийн сайдтай хамаарал бүхий, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд биш.

16. Би уул уурхайн компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд биш болно.
17. Би уул уурхайн компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшдэггүй болно.
18. Би биржийн томоохон харилцагчийн хувьцааны хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш. /нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/
19. Би биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон хяналтын багц эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой, төрөл, садангийн холбоогүй болно.
20. Би сүүлийн 3 жил биржийн эрх бүхий албан тушаал болон зөвлөх, хүний нөөц, шагнал урамшуулал хариуцсан ажилтнаар ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй болно.
21. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан.
22. Би Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлагуудыг хангаж байгаа болно.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ:.....

20... оны ... дүгээр сарын